**НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН**
**ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 01 сарын 17 өдөр Дугаар А/06 Улаанбаатар хот

## "Мөнгөн Улаанбаатар" өвлийн спорт, наадмын арга хэмжээнд оролцох тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.16, 30.2, 30.3, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Биеийн тамир, спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2, 13.1.3, нийслэлийн Засаг даргын 2020 оны "Тэмцээн зохион байгуулах тухай" А/32 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн төр захиргааны байгууллагуудын ажилтан, алба хаагчид, иргэдийг биеийн тамир спортын үйл ажиллагаанд татан оролцуулах, тэдний бие бялдрыг чийрэгжүүлэх, хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх, амралт, чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх зорилгоор 2020 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр Хандгайтын Янзага зусланд зохион байгуулагдах "Мөнгөн Улаанбаатар" өвлийн спорт наадмын арга хэмжээнд нийт алба хаагчдыг бүрэн хамруулсугай.

2. "Мөнгөн Улаанбаатар" өвлийн спорт, наадмын арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, тэмцээний удирдамжийг хоёрдугаар, шаардагдах зардлын тооцоог гуравдугаар хавсралтаар тус тус батлатсугай.

3. Өвлийн спорт, наадамд шаардагдах зардал 2.140.872 (хоёр сая нэг зуун дөчин мянга найман зуун далан хоёр) төгрөгийг зохих зардлаас гаргахыг Санхүү эдийн засгийн хэлтэс (дэд хурандаа Д.Урантулга)-т зөвшөөрсүгэй.

4. "Мөнгөн Улаанбаатар" өвлийн спорт, наадмын арга хэмжээнд оролцох алба хаагчдын замын хөдөлгөөний аюулгүй байдал, сахилга, зохион байгуулалтад хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын хэлтэс (дэд хурандаа Б.Баттулга)-т үүрэг болгосугай.

ДАРГА
ХУРАНДАА Ж.ЧУЛТЭМСҮРЭН

111715560I
УХА0038 9077073

D:/My documents-blank-2020-tushaal

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын
2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн
А/06 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

1117155601
УХА0038 9077873

# АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Нийслэлийн Онцгой байдлын газрын нийт алба хаагчдыг "Мөнгөн Улаанбаатар" өвлийн спорт наадмын арга хэмжээнд бүрэн хамруулах, биеийн тамир спортын үйл ажиллагаанд татан оролцуулах, тэдний бие бялдрыг чийрэгжүүлэх, амралт, чөлөөт цагийг цэвэр агаарт зөв зохистой өнгөрүүлэх, олон нийтийн оролцоог дээшлүүлэх үйл ажиллагааны бэлтгэл ажлыг хангуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

Ажлын хэсгийн ахлагч:

| | |
|---|---|
| Б.Баттулга | Захиргааны удирдлагын хэлтсийн дарга, дэд хурандаа, |

Гишүүд:

| | |
|---|---|
| Ш.Мэндсайхан | Нийслэлийн Аврах анги-105-ын захирагч, дэд хурандаа, |
| Б.Чинбат | Гамшгаас урьдчилан сэргийлэх хэлтсийн ахлах мэргэжилтэн, дэд хурандаа, |
| Ж.Алтанхуяг | Гал түймэртэй тэмцэх хэлтсийн Сургалт, гал түймэр унтраах асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, дэд хурандаа, |
| А.Чинбат | Санхүү эдийн засгийн хэлтсийн Хангалт үйлчилгээ, орон сууц, байрны ашиглалт хариуцсан мэргэжилтэн, дэд хурандаа, |
| Ж.Төмөрмандах | Дотоод, хяналт шинжилгээ, үнэлгээ, эрсдэлийн удирдлагын тасгийн дарга, хошууч, |
| Р.Мөнхбат | Захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн, хошууч, |
| Э.Эрдэнэбаатар | Санхүү эдийн засгийн хэлтсийн нягтлан бодогч, дэслэгч, |

Нарийн бичиг:

| | |
|---|---|
| Б.Баатар | Захиргааны удирдлагын хэлтсийн Судалгаа, дүн бүртгэл хариуцсан мэргэжилтэн, ахмад |

---oOo---

D/:My documents-blank-2020 tushaal

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын
2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн
А/06 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

1117155601
УХА0038 9077073

# "МӨНГӨН УЛААНБААТАР" ӨВЛИЙН СПОРТ, НААДМЫН АРГА ХЭМЖЭЭНД ОРОЛЦОХ АЛБА ХААГЧДЫН ДУНД ЗОХИОН ЯВУУЛАХ ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ

ЗОРИЛГО: Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн 2020 оны зорилтыг хэрэгжүүлэх үндсэн чиглэлийн хүрээнд нийслэлийн Онцгой байдлын газрын нийт алба хаагчдыг биеийн тамир спортын үйл ажиллагаанд татан оролцуулах, тэдний бие бялдрыг чийрэгжүүлэх, амралт, чөлөөт цагийг цэвэр агаарт зөв зохистой өнгөрүүлэхэд оршино.

1. Зохион байгуулах газар, хугацаа

Тэмцээнийг 2020 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 10:00-17:00 цагт Хандгайтын Янзага зусланд зохион байгуулна. Нээлтийн ажиллагаанд хэлтэс, анги салбарууд алба хаагчдыг бүрэн хамруулж, байгууллагын хаяг, тугтай нийслэлийн Засаг Даргын Тамгын газраас заасан талбайд 10.00 цагт жагссан байна.

2. Зохион явуулах үйл ажиллагаа, тэмцээн уралдаан

1. Олс таталтын тэмцээн – Баг тус бүрээс 4 эрэгтэй, 1 эмэгтэй тамирчин оролцоно. /Шүүгч хошууч Р.Мөнхбат/

Тэмцээнд: Гамшгийн шуурхай удирдлагын хэлтэс, Гал түймэртэй тэмцэх хэлтэс, Захиргааны удирдлагын хэлтэс, Гамшгаас урьдчилан сэргийлэх хэлтэс болон Санхүү эдийн засгийн хэлтэс, Гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төв, Нийслэлийн Аврах анги-105-аас тус бүр 1 баг оролцоно.

Багууд сугалаагаар 2 хэсэгт хуваагдах бөгөөд хэсгээс шалгарсан багууд тэргүүн байрын төлөө өрсөлдөнө.

2. Цасан дээрх мини хөлбөмбөгийн тэмцээн – Баг тус бүрээс 4 эрэгтэй тамирчин оролцоно. / Шүүгч дэд хурандаа А.Чинбат, дэд хурандаа Б.Чинбат /

Тэмцээнд оролцох багуудыг 2 хэсэгт хуваана. Эхэлж 2 гоол оруулсан баг хожно. Хэсгээс шалгарсан багууд 1, 2 дугаар байрын төлөө тоглоно.

3. Цасан дээрх Сумо тэмцээн – Баг тус бүрээс 2 тамирчин оролцоно. /Шүүгч хошууч Ж.Төмөрмандах/

Тамирчдын нэрийг бүртгүүлсэн дараалаар бичиж хамгийн эхний хүн сүүлийн хүнтэй таарах байдлаар нугалж унасан бөх хасагдах зарчмаар тэмцээнийг явуулж үзүүр, түрүүний бөхийг шалгаруулна.

3. Тэмцээний шагнал урамшил

Тэмцээнд тэргүүн байр эзэлсэн багуудыг уг тэмцээн зохион байгуулсан хэлтсээс шагнаж урамшуулна.

4. Нийслэлийн Засаг даргын тамгын газраас зохион байгуулах тэмцээн

1. Цасан дээрх бүжиг – / НОБГ 1 хос оролцоно/

2. Заагдсан талбайд /30м2/ цасан хотхон байгуулах - / Аврах анги /

3. Биеийн тамир, спортын хамтлагийнхаа үйл ажиллагааг сурталчлах /Захиргааны удирдлагын хэлтэс/

4. Байгууллага хамт олныхоо дунд эрүүл хүнс бэлтгэн үдийн цай, зоог зохион байгуулах /Санхүү эдийн засгийн хэлтэс/

Жич: Нэгдсэн арга хэмжээнд алба хаагчдыг идэвхтэй бүрэн хамруулах сахилга, дэг журам, идэвх оролцоо, зохион байгуулалтад хяналт тавьж ажиллахыг харьяа бүтцийн нэгжүүдийн дарга, захирагч нарт үүрэг болгож байна.

---oOo---

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын
2020 оны 01 дүгээр сарын ..-ны өдрийн
... дугаар тушаалын гуравдугаар хавсралт

1117155601
УХА0033 9077073

## "МӨНГӨН УЛААНБААТАР" ӨВЛИЙН СПОРТ, НААДМЫН АРГА ХЭМЖЭЭНД ОРОЛЦОХОД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

| № | Зардлын төрөл | Зардлын тооцоо |
|---|---|---|
| 1 | Хоол хүнсний зардал | 1,049,960 |
| 2 | Шатахууны зардал | 1,090,912 |
| | Нийт дүн | 2,140,872 |

## ШААРДАГДАХ ХҮНСНИЙ МАТЕРИАЛЫН ТООЦОО

| Д/д | Материалын нэр | Хэмжих нэгж | нэг хүний норм | хүний тоо | Тоо хэмжээ | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Хоолны материал | | | | |
| 2 | Үхрийн мах | кг | | | 10 | 10,500 | 105,000 |
| 3 | Хонины мах | кг | 0.42 | 80 | 33.6 | 9,600 | 322,560 |
| 4 | Гурил | кг | 0.1 | 80 | 8 | 1,200 | 9,600 |
| 5 | Байцаа | кг | 0.15 | 80 | 12 | 2,500 | 30,000 |
| 6 | Сонгино | кг | 0.04 | 80 | 3.2 | 1,500 | 4,800 |
| 7 | Перц | ш | 0.03 | 80 | 2.4 | 1,000 | 2,400 |
| 8 | Давс | ш | 0.025 | 80 | 2 | 1,000 | 2,000 |
| 9 | Хуурай цай | ш | 0.05 | 80 | 4 | 2,500 | 10,000 |
| 10 | Лууван | кг | 0.04 | 80 | 3.2 | 2,000 | 6,400 |
| 11 | Төмс | кг | 0.5 | 80 | 40 | 1500 | 60,000 |
| 12 | Манжин | кг | 0.02 | 80 | 1.6 | 2,000 | 3,200 |
| 13 | Ногоон огурцы | кг | | | 4 | 6,500 | 26,000 |
| 14 | Талх /хар/ | ш | 0.3 | 80 | 24 | 1,850 | 44,400 |
| 15 | Аарц | кг | 0.06 | 80 | 4.8 | 4,500 | 21,600 |
| 16 | Элсэн чихэр | кг | 0.07 | 80 | 5.6 | 2,500 | 14,000 |
| 17 | Масло | кг | 0.03 | 80 | 2.4 | 10,000 | 24,000 |
| 18 | Сүү | л | 0.2 | 80 | 16 | 2,500 | 40,000 |
| 19 | Ургамалын тос | л | 0.025 | 80 | 2 | 4,500 | 9,000 |
| 20 | Дупу | кг | | | 10 | 1,500 | 15,000 |
| 21 | Майноз | кг | | | 1 | 9,500 | 9,500 |
| 22 | Хиам | кг | | | 2 | 12,000 | 24,000 |
| 23 | Юуцай | боодол | | | 5 | 3,500 | 17,500 |
| 24 | Өндөг | ш | | | 30 | 350 | 10,500 |
| | Нийт | | | | | | 811,460 |
| | | | Бусад бараа материал | | | | |
| 25 | Нэг удаагийн аяга | ш | | | 200 | 100 | 20,000 |
| 26 | Нэг удаагийн таваг | ш | | | 200 | 100 | 20,000 |
| 27 | Нэг удаагийн сэрээ | ш | | | 200 | 80 | 16,000 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 28 | Чигчлүүр | боодол | | | 4 | 1,000 | 4,000 |
| 29 | Нойтон салфетка | ш | | | 2 | 5,500 | 11,000 |
| 30 | Хуурай салфетка | ш | | | 5 | 3,500 | 17,500 |
| 31 | Түлээ /мод/ | шуудай | | | 15 | 5,000 | 75,000 |
| 32 | Газ | л | | | 20 | 2,600 | 52,000 |
| Нийт | | | | | | | 238,500 |
| Нийт дүн | | 1,049,960 | | | | | |

## ШААРДАГДАХ ШАТАХУУНЫ ТООЦОО

| № | Газар хэлтэс | Автомашин | | | Явах зай, км | Шатахуун | | Үнэ, төгрөг | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | марк | дугаар | шатахуун, л/км | | Зарцуулах, км | төрөл | нэгж | нийт |
| 1 | НОБГ | Ланд-200 | 24-91УБЛ | 23 | 160 | 36.8 | АИ-92 | 1,840 | 67,712 |
| 2 | | Киа рио | 08-41 УНҮ | 9 | 80 | 7.2 | АИ-92 | 1,840 | 13,248 |
| 3 | | Киа рио | 08-42 УНҮ | 9 | 80 | 7.2 | АИ-92 | 1,840 | 13,248 |
| 4 | | Киа рио | 08-43 УНҮ | 9 | 80 | 7.2 | АИ-92 | 1,840 | 13,248 |
| 5 | | Киа рио | 08-46 УНҮ | 9 | 80 | 7.2 | АИ-92 | 1,840 | 13,248 |
| 6 | | Старекс | 87-62 УНТ | 18 | 160 | 28.8 | АИ-92 | 1,840 | 52,992 |
| 7 | | Автобус | 15-36 УБИ | 22 | 80 | 17.6 | Дизель | 2,450 | 43,120 |
| 8 | Нийслэлийн Аврах анги-105 | Старекс /аврах/ | 87-52УНТ | 18 | 80 | 14.4 | АИ-92 | 1,840 | 26,496 |
| 9 | | Старекс /эмнэлэг/ | 55-49 УНЯ | 18 | 80 | 14.4 | АИ-92 | 1,840 | 26,496 |
| 10 | | Фургон | 68-79УАА | 18 | 80 | 14.4 | АИ-92 | 1,840 | 26,496 |
| 11 | | КАМАЗ АСА-20 | | 45 | 80 | 36 | Дизель | 2,450 | 88,200 |
| 12 | | Зил 131 | 41-46 УНЦ | 45 | 80 | 36 | АИ-92 | 1,840 | 66,240 |
| 13 | | ЗИЛ-130 | 58-79 УБЛ | 38 | 240 | 91.2 | АИ-92 | 1,840 | 167,808 |
| 14 | | Випер | 57-66 УБС | 22 | 240 | 52.8 | Дизель | 2,450 | 129,360 |
| 15 | | КАМАЗ АСА-20 | 71-40 УНВ | 45 | 80 | 36 | Дизель | 2,450 | 88,200 |
| 16 | | MAN | 85-47 УБЧ | 20 | 80 | 16 | Дизель | 2,450 | 39,200 |
| 17 | | Мотort хөрөө | STIHL | 2 | 16 | 32 | АИ-92 | 2,450 | 78,400 |
| 18 | | Моторт хөрөө | Хятад | 1.5 | 16 | 24 | АИ-92 | 2,450 | 58,800 |
| 19 | | цахилгаан үүсгүүр | Хятад | 2 | 16 | 32 | АИ-92 | 2,450 | 78,400 |
| НИЙТ | | | | | | | | | 1,090,912 |

--o0o--